

ТАНИЛЦУУЛГА

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан бөгөөд энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.19-т “Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно.” гэж заасан.

Дээрх хуулийн заалттай холбогдуулан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, жороо морины уралдааны эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай болсон.

1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр Уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулсаар ирсэн бөгөөд жороо морины уралдааныг зохион байгуулах, уяачид цол, чимэг олгох зохицуулалт нь тодорхойгүй байсан.

Үндэсний их баяр наадмаар зохион байгуулах жороо морины уралдааны уяачид улс, аймаг, сумын цол, чимгийг олгох нь эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, наадамчин олны жороо морио дээдлэн хүндлэх, хайрлах, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Адуу болгонд байдаггүй жороолох өвөрмөц явдал нь эрт үеэс морьтон Монголчуудын ажигч гярхай нүдэнд өртөж улмаар жороо мориог аянд унах нь бараг үгүй дээдлэн хайрлан, найр наадам, баяр ёслол, гоёлд унадаг унаа нь болон уламжлагдаж ирсэн өнө эртний баялаг түүхтэй өв соёл юм.

Адууны сайварлах, жороолох явдлыг нүүдэлчин ахуй амьдралын ухаан туршлагаараа ялган ангилан, байгалийн үзэгдэл, амьтны хөдөлгөөнтэй зүйрлэн усан тэлмэн жороо, хонин жороо, тэмээн жороо зэргээр нэрлэж хэрэглэгдсээр ирсэн өв соёл, түүхэн уламжлалыг хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон болно.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо зөрчилдөхгүй бөгөөд жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачид улс, аймаг, сумын цол, чимэг олгох эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмж тусгасан.

Дээрх хуулийн зохицуулалт нь үндэсний морин уралдааны төрлийг нэмэгдүүлэх, эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, жороо морио дээдлэн хүндлэх, хайрлах, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн Уяачдын наадмаар уламжлагдан зохион байгуулж ирсэн жороо морины уралдааныг хөгжүүлэх нь Монголын өв соёл, уламжлал, зан заншлыг түгээн дэлгэрүүлэхэд бодит хувь нэмэр оруулах болно.

Хуулийн төсөлд дээрх зохицуулалтыг оруулснаар дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж байна. Үүнд:

-Хуулийн төсөл батлагдсанаар эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины өв соёлыг ирээдүй хойч үедээ түгээн дэлгэрүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

-Жороо морины уралдааныг хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, уяачдын идэвх, санаачилга, эрх зүйн байдал дээшилнэ.

-Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

- Үндэсний их баяр наадмаар жороо морины уяачийн эрх, үүрэг тодорхой болно;

-Жороо морины уяачийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, жороо морины уралдааныг зохион байгуулах эрх зүйн нөхцөл бүрдэнэ;

- Хууль хоорондын уялдаа холбоо сайжирна.

---o0o---